



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.08.27 № 1322

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР  
ДЭВШИХ ИРГЭН Ц.САРАНТУЯА  
ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвших иргэн Цэндсүрэнгийн Сарантуяагийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэн нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилтод нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлэн хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд бие даан нэр дэвших иргэний сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа 2050”, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

Иргэн Цэндсүрэнгийн Сарантуяагийн нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны ээлжит сонгуульд бие даан нэр дэвшихээр ирүүлсэн сонгуулийн

мөрийн хөтөлбөр, түүнд тусгагдсан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, "Алсын хараа-2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Иргэн Цэндсүрэнгийн Сарантуяагийн сонгуулийн мөрийн хөтөлбөр (2 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Нийслэлийн Сонгуулийн хороонд

Хавсралт: 2 хуудастай

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.НОМИНБААТАР



**НИЙСЛЭЛИЙН ИТХ-ИЙН 2020 ОНЫ СОНГУУЛЬД  
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ Ц.САРАНТУЯАГИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

2020 оны 7-р сарын 23-ны өдөр

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад иргэний төлөөлөл, иргэдийн хяналт зайлшгүй байх ёстой. Өнөөгийн байдлаар улс төрийн нам эвслээс иргэдийн төлөөлөгчдийн хуралд нэр дэвшүүлж ирсэн нь иргэдийн төлөөлөл гэхээс илүүтэй нам, эвслийн төлөөлөн болон ажиллаж, улмаар нийслэлийн төр захиргааны байгууллагын удирдах ажилтнууд, төрийн албан хаагчдыг халж солихдоо улс төрийн томилгоо хийх байдлаар намаа төлөөлдөг бүрүү хэвшил тогтсон байдаг. Үүнийг өөрчлөх арга зам бол иргэдийн төлөөлөгчдийн хуралд бие даагчдын оруулах замаар иргэдийн хяналтыг бий болгох явдал юм.


Иймд миний бие Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд бие даан нэр дэвшиж, сонгогдон иргэний төлөөлөл, хяналтын үүргийг гүйцэтгэн ажиллах болно. Үүний тулд: **Иргэнээ сонсдог, иргэний хяналттай, иргэний оролцоотой** төрийг бий болгох төлөө НИТХ-д ажиллах болно.

**Нэг. Иргэнээ сонсдог төр**

- 1.1. Нийтийн эрх ашгийг хөндөх аливаа шийдвэрийг Нийслэлийн иргэдээс асууж шийддэг асуулгын тогтолцоог нэвтрүүлнэ.
- 1.2. Иргэний гомдол, санал хүлээн авах мэдээллийн төвийг байгуулж, утас, мэйл, чат, мэйл, аппликэшн зэрэг мэдээллийг сүвгийн ажиллагааг сайжруулна.
- 1.3. Иргэний санал санаачилгыг хүлээн авах, дэмжих, эргэх холбоотой ажиллах мэдээлэл харилцааны шинэ сүвгийг ажиллуулна.
- 1.4. Иргэний шуурхай мэдээллийн дагуу нийслэлд буй аливаа зөрчил мэдээллийг шуурхай шийдвэрлэх, хариуцлага тооцох арга замыг нэвтрүүлнэ.
- 1.5. “Иргэний танхим”-ыг сэргээж, иргэдийн дунд хэлэлцүүлэг өрнүүлэх, мэдээлэл өгөх, иргэдийг сонсох, иргэдийн оролцоог дэмжих төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

**Хоёр. Иргэний хяналттай төр**

- 2.1. НИТХ-ын хуралдаанд иргэдээс оролцуулдаг, НИТХ-ын үйл ажиллагаатай иргэд танилцдаг журам боловсруулан хэрэгжүүлнэ.
- 2.2. Төлөөлөгчид эргээд иргэд, сонгогчидтойгоо ажиллах, жил бүр тайлан тавих ажлыг журамлан, хэрэгжүүлнэ.
- 2.3. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг нийслэлийн төр захиргааны байгууллагууд хэмжээнд хэрэгжүүлэх ажилд манлайлан оролцоно.
- 2.4. Нийслэлийн газрын мэдээллийн санг нээлттэй болгох ажлыг холбогдох төрийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.
- 2.5. Нийслэлийн худалдан авах ажиллагааг бүрэн цахим болгоно.



- 2.6. Нийслэлд тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахим болгож, шийдвэр гаргах процессыг шилэн болгоно.

**Гурав. Иргэний оролцоотой төр**

- 3.1. Нийслэлийн төсөв хэлэлцэхдээ иргэдийн санаа бодлыг тусгах, иргэдээс гарсан бүтэн байгуулалтын төсөл арга хэмжээг хэлэлцдэг, дэмждэг, санхүүжүүлдэг, хэрэгжүүлдэг тогтолцоог бий болгоно.
- 3.2. Иргэд ухаалаг програм ашиглан нийслэлийн төр захиргааны байгууллагын шийдвэр гаргах, иргэдийн санал гомдлыг шийдвэрлэх процессыг хөндлөнгөөс хянадаг, явцыг ажигладаг болно.
- 3.3. Иргэд аливаа хэрэг зөрчлийг мэдээлэх, амьдрах орчноо сайжруулахтай холбоотой санал санаачилгаа шийдвэр гаргагчид руу мэдээлдэг, хэлэлцүүлж, шийдвэрлүүлдэг болно. Энэ асуудлыг гар утасны аппликэшн ашиглан шийдвэрлэнэ.
- 3.4. Иргэд НИТХ-д илгээсэн төлөөлөгчөөрөө дамжуулан НИТХ-д өөрсдийн саналыг тусгуулдаг тогтолцоог журамлаж шийдвэрлэнэ.
- 3.5. Төр захиргааны байгууллагаас гаргах нийтийн эрх ашгийг хөндсөн шийдвэрт санал өгдөг болно.
- 3.6. Нийслэлийн төр, захиргааны байгууллагаас гаргасан зарим буруу шийдвэрийг эсэргүүцэх, шийдвэрийг цуцлуулах боломжтой болно.

